

## **ОУСК-ийн 15 сая ам.долларын зээлийн гэрээнд гарын үсэг зурав**

ХААН Банк болон Олон улсын санхүүгийн корпораци /ОУСК/ 2007 оны арванхоёрдугаар сарын 19-нд зургаан жилийн хугацаатай 15 сая ам.долларын зээлийн гэрээнд гарын үсэг зурлаа. Энэхүү зээлийг манай орны бизнес эрхлэгч, байгууллага болон хувь хүмүүст тэдний бизнесийг ергэтгэх, өсөж, дэвжихэд нь зориулан олгох юм.

Дотооддоо үйл ажиллагаа эрхэлдэг бүхий л бизнес эрхлэгчид уг зээл нээлттэй бөгөөд зээлийн энэхүү хөтөлбөр Монгол орны бизнесийн өнөөгийн түвшинд түлхэц өгөхөд чиглэгдэнэ.

“Монгол улсын өнцөг булан бүрт байгаа хэрэглэгчдэд хүрч, орон даяар санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг хүртээмжтэй чанарт нь болж ОУСК манай банктай хамтран ажиллахыг хүссэн. Уг зээлийг бид улс даяар үйл ажиллагаагаа явуулж буй 460 гаруй салбараараа дамжуулан бизнес эрхлэгчдэд хүргэх болно” хэмээн ХААН Банкны Гүйцэтгэх захирлын орлогч Барри Маддамс онцоллоо.

Posted date : 2007-12-20



### **БНСУ-д төлөөлөгчийн газраа нээсэн Монголын анхны банк ХААН Банк боллоо**

ХААН Банкны БНСУ дахь төлөөлөгчийн газрыг нээх ёслолын ажиллагаа энэ сарын 23-ны өдөр Севл хотноо боллоо. Ингэснээр ХААН Банк нь Монголын арилжааны банкуудаас төдийгүй хөгжиж буй орнуудаас төлөөлөгчийн газраа БНСУ-д нээсэн анхны арилжааны банк болж байгаа юм.

Тус улсын эрх бүхий байгууллагын зүгээс тавьсан эрх зүйн бүхий л шаардлагыг хангаж чадсан ХААН

Банкны санхүү үйл ажиллагааны үзүүлэлт, банкны үйл ажиллагаанд өгсөн олон улсын үнэлгээ, рейтинг зэргийг харгалзан үзсэнээр төлөөлөгчийн газраа нээх эрхийг өгсөн байна.

Энэхүү төлөөлөгчийн газрын нээлтийн ажиллагаанд ХААН Банкны удирдлагуудаас гадна төрийн байгууллагын хүмүүс оролцсон байна. Мөн Монгол Улсаас БНСУ-д суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд П.Үржинлхүндэв нээлтийн ажиллагаанд хүрэлцэн ирж, ХААН Банкны төлөөлөгчийн газар БНСУ-д албан ёсоор нээгдэж байгаа нь тэнд ажиллаж амьдарч байгаа монголчуудад амин чухал хэрэгцээтэй талаар онцлон тэмдэглэжээ.

“БНСУ дахь өөрийн түнш банкуудтайгаа хамтран тэдгээрээр дамжуулан Солонгос дахь монголчуудад банкны чанартай үйлчилгээг үзүүлж ирсэн бөгөөд 2006 оны арванхоёрдугаар сард төлөөлөгчийн газар нээх хүсэлт гаргасан. Бид БНСУ дахь үйл ажиллагаагаа цаашид өргөжүүлж, харилцагчид, тэдний гэр бүлд өсч дэвжихэд нь туслалцаа үзүүлэхийг зорьж ажиллах болно” гэж ХААН Банкны Гүйцэтгэх захирал Питер Морроу хэлсэн байна.

ХААН Банк нь 2005 оноос эхлэн Солонгосын банкуудтай тогтоосон харилцаагаа түшиглэн БНСУ-д ажиллаж амьдарч буй монголчуудад банкны үйлчилгээ хүргэж эхэлсэн

билээ. Шинээр нээгдсэн телеелегчийн газрынхаа вйл ажиллагааг эрчимтэй явуулахын зэрэгцээ Солонгос улсын Шинхан банк, Куумин банк, Кория Эксчэйнж банкттай тогтоосон харилцаагаа улам бүр ергежүүлэх талаар тус банкныхан ярьж байлаа.

Ийнхүү ХААН Банкны Телеелегчийн газар албан ёсоор нээгдэж байгаа нь цаашид банк санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэх эхний алхам болж байгаа юм. БНСУ-ын хуулиар банкны салбараа нээх тохиолдолд телеелегчийн газраа урьдчилан нээж, жигд ажиллуулах шаардлагатай байдаг бөгөөд тодорхой шалгууруудыг давсны дараа банкны салбар нээх зөвшөөрлийг өгдөг байна.

Posted date : 2007-11-23

### **ХААН Банк Азийн Хөгжлийн банкттай 10 сая ам.долларын урт хугацааны зээлийн гэрээнд гарын үсэг зурав**



ХААН Банк нь томоохон бизнесийн байгууллагуудын зээлийн хэрэгцээг есөн нэмэгдэж буйг хангах үүднээс АХБ-тай 10 сая ам.долларын урт хугацааны зээлийн гэрээнд гарын үсэг зурснаа зарлаж байгаадаа таатай байна. ХААН Банк нь улс орон даяар тархан байрласан 470 салбар нэгжүүдээрээ дамжуулан жижиг, дунд вйлдвэрлэлийг дэмжин зээл болон бусад санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэх вйл ажиллагаанд тэргүүлэн оролцсоор ирсэн

уламжлалтай билээ. Мөн Монгол улсын эдийн засгийн есэлт сайн байгаа өнөөгийн нөхцөлд ихээхэн үүрэг гүйцэтгэж байгаа Монголын томоохон аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх тал дээр ч ХААН Банк ихээхэн анхаарал тавьж голлох үүрэгтэйгээр оролцож байна. АХБ-ны урт хугацааны зээлийн тусламжтайгаар ХААН Банк нь томоохон аж ахуйн нэгж, компаниудад урт хугацааны долларын зээлийг бага хүүтэйгээр олгох боломжийг нээж, аж ахуйн нэгж, компаниудад бизнесээ бэхжүүлэх, цаашид хамгийн боломжит хэмжээнд өсөж хөгжихөд нь түлхэц болох юм. “Томоохон компаниудын өсөлтийг дэмжинэ гэдэг нь эдийн засгийн олон талт тогтвортой хөгжлийг бүрэлдүүлэхэд нэн чухал юм. Харин тэдгээр компаниудын өсөж, хөгжих явдал нь тэдгээрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн зээл, санхүүгийн үйлчилгээнээс хамааралтай” гэж АХБ-ний Хувийн секторын вйл ажиллагааны газрын хөрөнгө оруулалтын мэргэжилтэн Жоанна Клейн хэлсэн байна. ХААН Банкны Гүйцэтгэх захирлын орлогч Барри Маддамс хэлэхдээ “Бид урьд нь салбар нэгжүүдийнхээ сүлжээгээр дамжуулан олон тооны төслүүд дээр хамтран ажиллаж байсан АХБ-тай харилцаагаа ергежүүлж байгаадаа баяртай байна. Өнөөг хүртэл манай зах зээл дээр өргөн хэрэглэгдэж байсан өндөр өртөгтэй, богино хугацааны зээлүүд нь томоохон ААН-дийн вйл ажиллагаанд чөдөр болж байсан бол энэхүү шинэ зээлийн тусламжтайгаар бид зарим томоохон харилцагчиддаа тэдэнд нэн хэрэгцээтэй байгаа урт хугацааны санхүүжилтыг олгох боломжтой болох юм.” ХААН Банк нь бусад олон улсын байгууллагуудтай санхүүжилтын гэрээнүүдэд гарын үсэг зурж байгаа бөгөөд тэдгээр нь Монголын эдийн засгийн ирээдүйн хөгжилд тус банкны оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх юм.

Posted date : 2007-11-19

## **ХААН Банк “Moody’s”-ээс дээд зэрэглэлийн үнэлгээ авлаа**

Херенгийн үнэлгээ, эрсдлийн дшн шинжилгээ хийдэг дэлхийн хамгийн нэр хүндтэй байгууллага болох “Moody’s Investment service”-ээс ХААН банкны вйл ажиллагаанд үнэлгээгээ өгчээ.

Moody’s-ийн үнэлгээгээр тус банкны санхүүгийн чадавхи-D, урт болон богино хугацааны дотоодын валютын депозитийн үнэлгээ Ваа3/Prime3, урт богино хугацааны гадаад валютын үнэлгээ B2/NP хэмээн тодорхойлсон байна.

“Moody’s Investment service”-ийн Тайвань дахь салбарын Дэд ерөнхийлөгч Черри Хуанг “Эдгээр үнэлгээнээс харахад ХААН банк нь жижиг болон бичил бизнесийн санхүүжилт дээр тэргүүлэгч байр суурьтай, зээл болон хадгаламжийн зах зээлийн дийлэнх хувийг эзэлдэг, тогтвортой бөгөөд туршлагатай удирдлагын багтай, ашиг орлого сайтай херенгийнхөө чанарыг улам бүр сайжруулж байгаа банк гэдэг нь харагдаж байна” хэмээн онцолжээ.

“Moody’s Investment service”-ээс ХААН Банкны урт болон богино хугацааны дотоодын валютын депозитод Ваа3 үнэлгээ өгсөн нь херенге оруулалтын түвшиний үнэлгээ бөгөөд энэ нь Монгол улсад өмнө нь аль ч байгууллага авч байгаагүй хамгийн өндөр херенге оруулалтын түвшиний үнэлгээ ажээ.

ХААН Банкны Гүйцэтгэх захирал Петер Морроу хэлэхдээ “Манай хамт олны мэргэжлийн өндөр ур чадвар, менежментийн хичээнгүй хөдөлмөрийн үр дүнд Moody’s шиг нэр хүндтэй, олон улсын томоохон байгууллагаас ийм хэмжээний үнэлгээ авсан нь бидэнд их урам хайрлаж байна” гэжээ.

ХААН банк нь олон улсын хэмжээнд үнэлгээ өгдөг хоёр том байгууллагаас үнэлгээ авсан Монголын цорын ганц банк болж байгаа бөгөөд энэ оны эхэнд, “Fitch Rating”-ээс “Вйл ажиллагааны үзүүлэлт, бизнесийн сүлжээгээрээ бусдаас тэргүүлэгч банк” гэсэн үнэлгээг авсан билээ.

Posted date : 2007-11-19

## **ХААН Банкны вйлчилгээг Монголын Үндэсний Шилдэг Вйлчилгээгээр шалгаруулав**

Монголын Үндэсний Худалдаа Аж Вйлдвэрийн Танхим, Монголын Үндэсний шилдэг ерэн есөн бүтээгдэхүүн, вйлчилгээг шалгаруулах Үндэсний Хорооноос “Онлайн ба бодит ЭКСПО - Монголын Үндэсний Шилдэг 99 бүтээгдэхүүн, вйлчилгээ 2007” Тусгай хөтөлбөрт арга хэмжээг 2007 оны 11 дүгээр сарын 9 -12-ны хооронд “Мишээл Экспо” төвд зохион байгуулсан бөгөөд үзэсгэлэнгийн сүүлчийн өдөр Үндэсний шилдэг 99 бүтээгдэхүүн, вйлчилгээг шалгарууллаа. MVXAVT-аас 2 жилийн турш зохион байгуулсан 4 томоохон үзэсгэлэн худалдааны дүн дээр үндэслэн 2 жилд нэг удаа дотоодын шилдэг бүтээгдэхүүн, вйлчилгээг нэрлэдэг байна.

ХААН Банк энэхүү арга хэмжээнд банк санхүүгийн вйлчилгээ үзүүлэн идэвхтэй оролцоор ирсэн тул ХААН Банкнд Монгол улсад үндэсний вйлдвэрлэл, вйлчилгээг хөгжүүлэх, эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэхэд идэвхи санаачилга гарган,

вйлчилгээндээ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, оновчтой маркетинг, менежмент ашиглан хэрэглэгчдийн таашаалыг зүй ёсоор хүлээсэн Монгол улсын бүх аймаг сумдад салбараа нээж үйлчилгээ үзүүлж байгааг Монголын Үндэсний Шилдэг Вйлчилгээгээр шалгаруулж “ҮЛЭМЖИЙН ЧАНАРЫН БАТЛАМЖ” олгосон юм.

Дашрамд дурьдахад бид тус арга хэмжээнд ХААН Банкны Инкубатор-зөвлөх үйлчилгээ, Автомашины лизингийн зээлийн үйлчилгээ, “Солонгост ажиллаж амьдарч байгаа Монголчууддаа” гэсэн 3 бүтээгдэхүүнээр оролцсон юм. Эдгээр Монголын Үндэсний Шилдэг үйлчилгээгээр шалгарсан бүтээгдэхүүнүүдийн талаар товч дурдья.

Posted date : 2007-11-13



### **ХААН Банк Галшар суманд 10 дахь мэдээллийн төвөө нээлээ**

Хөдөө орон нутгийн нийгмийн хөгжлийг дэмжих зорилгоор алслагдсан сумдыг интернэт сүлжээнд холбож буй ХААН Банкныхан Хэнтий аймгийн Галшар суманд шинээр мэдээллийн төвөө нээлээ. 2007 оны арваннэгдүгээр сарын 10-ны өдөр болсон уг нээлтийн ажиллагаанд хүрэлцэн ирсэн нутгийн иргэд дэвшилтэт техник технологийг ашиглан шинэ тутам мэдээллийг шуурхай авах боломжтой болж, харь газар болоод хотод сурч амьдарч байгаа үр хүүхэд, ах дүүстэйгээ хялбарханаар холбогдох болсондоо баярлаж, талархаж байгаагаа илэрхийлж байв. Тус сумын Засаг дарга мэдээллийн төвийн нээлтийн ажиллагааны үеэр хэлсэн үгэндээ “Галшарын морьд хурднаараа алдартай. Одоо тэгвэл Галшарынхан өндөр хурдтай интернэтийн тусламжтай дэлхийн энцэг буланд хүрч мэдээлэл олж чадах боллоо” хэмээн тэмдэглэсэн юм. ХААН Банк сүүлийн хоёр жилийн турш банкны сүлжээгээ ашиглан алслагдсан сумдыг интернэтэд холбох болсон бөгөөд Галшар арав дахь сум нь болж байгаа юм. ХААН Банк хөдөөгийн сумдад мэдээллийн төв байгуулах ажиллагаагаа 2005 оны есдүгээр сард Архангайн Батцэнгэл сумаас эхэлж байжээ. Сумын Засаг даргын Тамгын газар болоод дунд сургуулийн дэргэд байгуулж буй мэдээллийн төвүүд нь дэлхий дахинд болж буй мэдээллийг цаг алдалгүй хямд төсөр үнээр авах боломжийг өгч, хүүхэд залуучуудад чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрөөхөд нь тусалж байна

Posted date : 2007-11-10

### **ЕСБХБ-ны 50 сая ам долларын санхүүжилт бүхий санхүүгийн салбарыг бэхжүүлэх зорилготой үйл ажиллагааны чиглэлд хамрагдах санхүүгийн байгууллагуудын анхдагчаар ХААН БАНК тодорлоо**



ХААН Банк 2007 оны 10-р сарын 30-ны өдөр Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)-тай хамтын ажиллагааны хоёр томоохон гэрээг үзэглэсэн байна. Түвш байгууллагууддаа зээлийн болон хувьцааны санхүүжилт олгон улмаар тэд хувь хүмүүс болон арилжааны хэрэглэгчдэд дамжуулан зээлдүүлэх зарчим бүхий ЕСБХБ-ны 50 сая ам долларын энэ багц төслийн ашиг тусыг хүртэх Монголын санхүүгийн байгууллагуудын анхдагчаар ХААН

Банк тодорлоо. 61 улс, засгийн газар хоорондох хоёр байгууллагын эзэмшилд байдаг ЕСБХБ нь төвлөрсөн эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж буй төв Европын болон төв Азийн улс орнуудын эдийн засгийн шилжилтийг дэмжих зорилгыг өмнөө тавьдаг. Энэ санхүүжилтийн хүрээнд 10 сая ам долларын зээл олгох бөгөөд уг зээлийг бичил, жижиг дунд аж ахуйн нэгжүүд, компаниудын өсөлт, хөгжлийг дэмжих зориулалтаар дамжуулан зээлдүүлэх болно. Зээлээс гадна, ЕСБХБ нь ХААН Банкныг өөрийн хэрэглэгчиддээ хүргэх санхүүгийн үйлчилгээний цар хүрээг өргөтгөхөд нь туслах зорилгоор худалдааны санхүүжилтийн нэг сая хүртэлх ам долларыг олгох болно. Тус мэдээллийг Зээлийн Хэлэлцээрт мягмар гаригт гарын үсэг зурах ёслол, хэвлэлийн бага хурал хийлгэх үед танилцуулсан бөгөөд уг арга хэмжээнд ХААН Банкны Гүйцэтгэх Захирал Ж. Питер Морроу, ЕСБХБ-ны Санхүүгийн Байгууллагуудын асуудал хариуцсан Бизнесийн Группын Захирал Курт Гайгер, ЕСБХБ-ны Монголыг хариуцсан захирал Жон Чоел-Доу болон хоёр байгууллагын бусад төлөөлөгчид байлцлаа. Гэрээнд гарын үсэг зурах үеэр ХААН Банкны Гүйцэтгэх захирал Питер Морроу “Энэхүү урт хугацааны таатай нөхцөл бүхий санхүүжилт нь ХААН Банкны Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа бичил болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч өөрийн харилцагчиддаа бага хүүтэй зээл олгох боломжийг нэмэгдүүлж байна.” хэмээн онцлон тэмдэглэсэн байна. Түүнчлэн тэрээр “Өнгөрсөн долоо хоногт олон улсын үнэлгээний Moody's агентлагаас авсан үнэлгээний нэг хэсэг нь хөрөнгө оруулалтын түвшиний үнэлгээ байгаа нь ийм төрлийн гэрээ хэлэлцээрийг дахин дахин байгуулж Монгол орны эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах боломжийг бидэнд олгож байгаа юм” хэмээн нэмж хэллээ. ЕСБХБ –ны Санхүүгийн Байгууллагуудын Бизнес Группын Захирал Курт Гайгер хэлэхдээ Монгол дахь банк санхүүгийн салбарыг дэмжих нь тус Банкны гол зорилго байх болно хэмээсэн байна. Шинэ багц төсөл нь ойр дотны бөгөөд харилцан ашигтай хамтын ажиллагааны нөхцөлийг бүрдүүлсэн байна. “ЕСБХБ нь Монгол дахь түнш байгууллагуудтайгаа маш ойр, нягт хамтран ажиллахыг эрмэлзэж байна. Банк санхүүгийн салбар дахь хөгжил дэвшил нь нийт эдийн засгийн хөгжилд ашиг тусаа авчрах бөгөөд яг үүнийг л бид хүсч байна” гэж тэрээр нэмж хэлсэн байна. ХААН Банк нь Монгол улс даяар байгууллагууд, хувийн хэвшлийн компаниуд болон хэрэглэгчид хувь хүмүүст санхүүгийн иж бүрэн үйлчилгээ үзүүлдэг үндэсний хэмжээний тэргүүлэгч банк юм. Тус банк нь Монгол орны өнцөг булан бүрт хүрсэн 450 гаруй салбар нэгж бүхий хамгийн өргөн салбарын сүлжээтэй бөгөөд эдгээрийн 263 нь бодит цагийн онлайн сүлжээнд холбогдон улс орон даяар аливаа гүйлгээг хормын дотор хийж үйлчилдэг. Монголын банк санхүүгийн системд өдөр тутамд хийгдэж буй гүйлгээний 70% нь тус банкаар дамжин хийгддэг юм. Ихэнх томоохон компани, аж ахуйн нэгжүүд, гадаадын компаниуд, олон улсын байгууллагууд, хандивлагчид болон ТТБ-ууд улс орон даяар хийгдэх банкны төлбөр тооцоогоо ХААН Банкны сүлжээг ашиглан үйлчлүүлдэг юм.

Posted date : 2007-10-30



### **Евромани сэтгүүл ХААН Банкныг 2007 оны шилдэг банкаар дахин тодрууллаа**

Олон улсын банк санхүүгийн нэр хүндтэй сэтгүүл болох Евромани сэтгүүл ХААН Банкныг 2007 оны Монгол улсын шилдэг банкаар тодрууллаа. 7 сарын 16 ний өдөр Хонг Конг улсад 2007 оны шилдэг байгууллагуудад шагнал гардуулах ёслолын ажиллагаанд тус банкны удирдах ажилтнууд

оролцон шагналаа хүлээн авсан байна. Евромани сэтгүүл нь олон улсын банк болон хөрөнгийн зах зээлийн хөгжил хандлагын талаар товч бөгөөд тодорхой мэдээллийн эх сурвалжийг хүргэдэг хамгийн нэр хүндтэй сэтгүүл бөгөөд жил бүр олон улсын бүсийн хэмжээнд тэргүүлэх банк санхүүгийн байгууллагуудыг шалгаруулдаг юм. ХААН Банк нь 2006 онд бүс нутгийн олон тооны банкуудаас шалгаран Монгол улсаас тус шагналыг хүртсэн анхны банк юм. Евромани сэтгүүлд “Монголд Худалдаа ХТөгжлийн банк, ХААН Банк гэсэн хоёр арилжааны банкууд өнгөрсөн онд сайн амжилттай ажилласан хэдий ч ХХБ-ны амжилт шилдэг банк хэмээх ергөмжлөлийг ХААН Банкнаас авахад хангалттай бус байсан ба ХААН Банк нь зээл, хадгаламж, салбарууд болон зээлдэгч нараараа улсдаа хамгийн том иргэдийн банк юм” хэмээн ХААН Банкныг үнэлсэн байна. ХААН Банкны Маркетингийн газрын захирал М. Чанцалмаа шагнал гардан авах ёслолын үеэр “Евромани сэтгүүл шиг ил тод, нэр хүндтэй байгууллагаас энэ шагналыг удаа дараа хүртэж буй маань маш хүндэтгэлтэй явдал юм. Энэ нь Монгол улс даяар нийт Төрхийн 80%-д хүрч үйлчилж буй манай ажилтнуудын шаргуу хөдөлмөр мөн бидэнд итгэл хүлээлгэн байнга бидэнтэй хамт байдаг харилцагчдын маань дэмжлэгийн үр дүн яах аргагүй мөн” гэж хэллээ.

Posted date : 2007-10-16

### **ХААН Банк “Монголд хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт”-ын ерөнхий ивээн тэтгэгчээр оролцлоо**



Олон улсын Евромани сэтгүүллээс Улаанбаатар хотод 9 дүгээр сарын 18-нд зохион байгуулагдсан Монголд хөрөнгө оруулагчдын олон улсын чуулга уулзалтын ерөнхий ивээн тэтгэгчээр ХААН Банк оролцлоо. Энэхүү чуулга уулзалт нь жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг бөгөөд ХААН Банк гурав дахь жилдээ хамтран ажиллаж байгаа юм. Монгол улсад гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, тэдгээрт хөрөнгө оруулалтын таатай нөхцлүүдийг таниулах, хэрэгцээтэй мэдээлэл хүргэх зорилгоор зохион

байгуулагддаг “Монголд хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт”-нд Засгийн газрын телеелегчид, олон улсын байгууллагууд, Монголд хөрөнгө оруулах сонирхолтой улс орнуудын телеелэл, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчид оролцлоо. Энэ жилийн чуулга уулзалт нь 2007 онд Монголд зохиогдож буй хамгийн өндөр түвшиний чухал үйл явдал болсон бөгөөд Улаанбаатар болон Нью Йорк хотуудад зохиогдсон өмнөх чуулга уулзалтуудын амжилтанд тулгуурласан томоохон арга хэмжээ боллоо гэж үзэж байна. “ХААН Банк энэхүү чуулга уулзалтыг жил бүр дэмжин ажиллаж байгаа нь Монгол улсын эдийн засагт гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг үүргийг өндрөөр үнэлэн өөрийн хувь нэмрээ оруулж буйн илрэл юм” гэж ХААН Банкны гүйцэтгэх захирал Питер Морроу хэлэв.

Posted date : 2007-10-16

### **ХААН Банкны Гүйцэтгэх захирал Питер Морроу “Алтан гадас” одонгоор шагнагдлаа**



ХААН Банкны Гүйцэтгэх захирал Ж. Питер Морроу-г 2007 оны 5 сарын 17-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 85 дугаар зарлигаар төрийн дээд шагнал болох “Алтан гадас”

одонгоор шагналаа. Шагнал гардуулах зарлигт : Монгол Улсын Ерөнхийлөгч Н. Энхбаяр ХААН Банкны Гүйцэтгэх захирал Питер Морроугийн Монгол Улсын Банк санхүүгийн системийн хөгжилд оруулсан хувь нэмэр, Монгол Улсын хамгийн ергөн сүлжээ, харилцагч бүхий ХААН Банкыг эдийн засгийн хямралт байдлаас нь гаргаж, өнөөгийн ололт амжилтыг бий болгоход гаргасан хүчин чармайлт, “хаана хүн байна, тэнд хүрч үйлчилнэ” гэсэн зорилт, түүнийгээ амьдралд хэрэгжүүлэн Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд тархан байрласан 443 салбар тооцооны төвүүдээрээ дамжуулан ард иргэд бүрт хүрч шударга, чанартай, соёлтой үйлчилгээ үзүүлж, хамт олноо чадварлаг удирдаж байгаа Ж. Питер Морроугийн менежментийн ур чадвар, туршлага, асар их хөдөлмөр, бүтээлч санаачлага, шударга зарчимч байр суурь, хамт олныг идэвхжүүлж, хүч, нөөц, боломжийг нь дайчлан ажиллах эв дүй, нэр хүнд, нэр их зүтгэлийг нь үнэлж Монгол Улсын төрийн дээд шагнал болох “Алтан гадас” одонгоор шагнав хэмээн өгүүлсэн байна. Ж. П. Морроу нь 2000 онд анх Монголд ирж тухайн үед үйл ажиллагааны бэрхшээл, санхүүгийн бэрхшээлтэй тулгарч байсан Хөдөө аж ахуйн банкны үйл ажиллагааг эрүүлжүүлэх зорилгоор томилогдон 2000 оны 7 дугаар сараас тус банкны гүйцэтгэх захирлаар одоог хүртэл ажиллаж Монгол Америкийн хамтарсан удирдлагын багийг үр бүтээлтэй удирдаж байна. Ж. П. Морроуг 2005 онд Монгол Улсын Ерөнхийлөгч гадаадын иргэнд олгодог хамгийн дээд шагнал болох “Найрамдал” медалиар шагнаж байсан юм.  
Posted date : 2007-10-15



### **ХААН Банк Сөвлийн гудамжинд төв банкны шинэ байрандаа орлоо**

ХААН Банк Улаанбаатар хотын төвд байрлах Сөвлийн гудамжинд төв банкны шинэ байрандаа орлоо. Хуучнаар хvvхэд залуучуудын театрын ергөтгөл болгон баригдсан шинэ барилга болон театрын барилгад ХААН Төв банк байрлаж үйл ажиллагаагаа явуулах юм байна. Монгол орны бүх л хот суурин, аймаг сумдад байдаг харилцагчдынхаа итгэлийг хүлээн ажилласны үр дүнд сөвлийн хэдэн жилийн дотор ХААН Банк нь хурдацтай ергэжин тэлж өнөөдрийн байдлаар орон даяар байрлах өөрийн 450 гаруй салбар, тооцооны төвөөрөө санхүүгийн иж бүрэн үйлчилгээг үзүүлж байна. Ийм ч учраас ХААН Банкны хувьцаа эзэмшигчид болон удирдлагууд банкны үйл ажиллагаанаас олсон ашгаа буцаан ноогдол ашиг болгон авах бус харин эргүүлэн монгол орны эдийн засгийн өсөлт, өөрийн банкны үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтад зарцуулсаар ирсний нэг жишээ нь олон улсын түвшинд хүрсэн арилжааны банкны байртай болсныг харуулж байна. Энэхүү байрны дотоод тохижилт, интерьер дизайн дээр олон улсын банк санхүүгийн байгууллагууд, бизнесийн томоохон компаниудын дизайныг гаргасан Солонгос улсын нэр хүндтэй Мин ассошиэтс компанийн дизайнер Мин ажиллажээ. ХААН Банкны шинэ төв байранд хэрэглэгчдийнхээ таалалд нийцэх орчин үеийн тохилог орчинд өндөр зэрэглэлийн харилцагчийн үйлчилгээг үзүүлэх өргөн боломж нээгдэх юм. Түүнчлэн ХААН Банк нь өөрийн гэсэн театртай анхны арилжааны банк гэдгээрээ онцлогтой бөгөөд театртаа ХААН Банк сангийн хүрээнд олон нийтийн арга хэмжээнүүд, олон улсын хурал чуулган, ивээн тэтгэлэгт төслүүддээ зориулсан гэх мэт арга хэмжээнүүдийг зохион байгуулах замаар хамгийн зүй зохистой байдлаар ашиглаж олон нийтийн хүртээл болгох зорилготой ажиллаж байна. Снгерсен хугацаанд ХААН Төв банкны газар хэлтсүүд нь Жуковын

музейн баруун талд байрлах еерийн байр болон УБ хотод хэд хэдэн газар байрлаж байсан. Харин энэхүү шинэ байрыг ашиглалтад оруулснаар ХААН Төв Банк газар хэлтсийн заримаас бусад нь Сөвлийн гудамжинд байрлах еерийн байрандаа нүүж ирлээ. ХААН Банкны харилцагч, хамтран ажилладаг байгууллагууд, түүншүүдэд хандаж хэлэхэд Төв банкны байр нь Сөвлийн гудамжинд Түшиг их дэлгүүр, 45 дугаар дунд сургуулийн дунд байрладаг бөгөөд та ХААН Банкны 33-23-33 дугаартай ресепшний утас болон ХААН Банкны лавлах 1917 утсанд холбогдож илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой юм байна.

Posted date : 2007-10-10

### **ХААН Банк УНДЕГ газартай хамтран Солонгос дахь Монголчууддаа зориулан едерлөг зохион байгууллаа**



ХААН Банк, Улсын нийгмийн даатгалын ерөнхий газартай хамтран есдүгээр сарын 23-ны едер БНСУ-ын үндэсний баяр, Ургацын баярыг тохиолдуулан тус улсад ажиллаж амьдарч байгаа монголчууддаа зориулан Сөвл хотод едерлөг зохион байгуулжээ. Едерлөгт 3000 гаруй хүн оролцсон байна. Едерлөгийн үеэр цугларсан монголчуудыг нийгмийн даатгалын үйлчилгээнд бүртгэх, банкны бүтээгдэхүүнүүдтэй танилцуулж урлаг соёлын нэртэй мастерууд оролцсон тоглолт зохион байгуулсан

байна. Энэхүү арга хэмжээнд УНДЕГ-ын дарга С.Эрдэнэ, ХААН Банкны удирдлагууд оролцон монголчууддаа баяр хүргэж санал сэтгэгдлийг сонслоо.

Posted date : 2007-09-26

### **ХААН Банк гурван сая дахь зээлээ олголоо**

Монгол Улсын өнцөг булан бүрт байрлах еерийн 443 салбар нэгжээрээ дамжуулан хот хөдөөгийн ард иргэдэд санхүүгийн иж бүрэн үйлчилгээ үзүүлдэг ХААН Банк 2007 оны 7 дугаар сард гурван сая дахь зээлээ олгосон байна. Энэхүү азтай зээлдэгчээр Дундговь аймгийн Элбэг Хайрхан ХХК тодорсон байна. ХААН Банкны удирдлага 2007 оны 8 сарын 17-ны едер ёслолын гэртээ тус банкны анхны ба гурван сая дахь зээлдэгч нарыг хүлээн авч уулзаж өргөмжлөд, мөнгөн шагналыг тус тус гардуулав. ХААН Банк анхны зээлээ 2000 оны 10 дугаар сард Дархан хотын иргэн Ц. Болдод олгож байсан юм байна. Ц. Болд нь тухайн үедээ бизнес эрхлэх зорилгоор авч байсан ба түүнээс хойш тус банкнаас удаа дараа зээл авч еерийн бизнесийн үйл ажиллагаагаа улам өргөжүүлсээр байгаа гэнэ. Гурван сая дахь зээлийн эзнээр тодорсон Элбэг Хайрхан ХХК-ний захирал А. Цолмонбаяр шагнал гардаж авахдаа “ХААН Банк 2007 оныг ЖДҮ дэмжих жил болгон зарлаж бизнес эрхлэгч бидэнд зориулан өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулж байгаад нь талархаж байна. Бид ХААН Банкнаас удаа дараа зээл авч үйл ажиллагаагаа өргөжүүлж, бизнес маань ч амжилттай явагдаж байгаад баяртай байдаг юм. Манай компанийн 4 дэх удаагийн 7 дугаар сарын 18-ны едер авсан зээл маань тус банкны гурван сая дахь зээлээр тодорсон нь миний хувьд их бэлэг дэмбэрэлтэй үйл явдал болж байна” гэв. ХААН Банкны Гүйцэтгэх Захирал П. Морроу шагнал гардуулах үеэр хэлэхдээ “Манай харилцагчид өөрсдийн санхүүгийн хэрэгцээндээ тохирсон ХААН Банкны бүх төрлийн үйлчилгээг авч байдагт бид байнга талархаж явдаг. Нийт зээлдэгчдээс жижиг бизнесийн эргэлтийн хөрөнгийн зээл авсан

зээлдэгч маань гурван сая дахь зээлийн эзнээр тодорсон нь ихээхэн зүй зохистой хэрэг болж байгаа юм. Учир нь жижиг дунд бизнес бол Монгол Улсын эдийн засгийн гол тулгуур багана, тиймдээ ч цаашдын хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулна. Зээлдэгч А. Цолмонбаяр болон бусад нийт зээлдэгчид, харилцагчиддаа бизнесийн ажилд нь ендер амжилт хүсье” гэсэн байна.

Posted date : 2007-08-20

### ■ **ХААН Банк “Дэнжийн 1000 – Авто худалдаа”-ны вээр лизингийн зээлийн хvv, урьдчилгаа телберее буурууллаа**

“Дэнжийн 1000” худалдааны төв буюу хуучин төв барааны зах, ХААН Банк хамтран 2007 оны 7 сарын 4-8-ны өдрүүдэд “ДЭНЖИЙН 1000 – АВТО ХУДАЛДАА” үзэсгэлэн яармаг зохион байгуулах гэж байна. Энэхүү үзэсгэлэнгийн гол зорилго нь Ардын хувьсгалын баяр наадмын өмнө автомашин худалдан авах, худалдах сонирхолтой байгууллага, аж ахуйн нэгжид нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх явдал юм.

Энэ удаагийн “Дэнжийн 1000 – Авто худалдаа” үзэсгэлэн яармагт ч гэсэн ХААН Банкны зүгээс ерөнхий санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагаар оролцон, хөнгөлттэй нөхцөл бүхий лизингийн зээлээр үйлчлэхийн сацуу нийт 15 азтай зээлдэгч шалгаруулна. Мөн үзэсгэлэнгийн өдөр бүрт ХААН Банкны зээлийн эдийн засагчид, харилцагчийн зөвлөхүүд ажиллан зээлийн өргөдөл хүлээн авч, газар дээр нь судлан, шийдвэр гарган зээл олгоно.

ХААН Банкнаас зөвхөн энэ өдрүүдэд бусад банкуудтай харьцуулахад хамгийн таатай нөхцөл бүхий лизингийн зээлийг санал болгож байгаа бөгөөд Дэнжийн 1000 худалдааны төвөөс автомашин худалдаалагчдыг үнэ төлбөргүй машин тавих талбайгаар хангаж байгааг дуулгахад таатай байна.

Манай лизингийн зээлийн нөхцөл доорх байдлаар өөрчлөгдөж байна:

Шинэ автомашинны зээлийн хvv		Хуучин автомашинны зээлийн хvv		Урьдчилгаа телбер
төгрөг	ам. доллар	төгрөг	ам. доллар	
1.5%	1.0%	1.8%	1.5%	10%

Иймд танай байгууллага уг үзэсгэлэнд оролцож бизнесээ олон нийтэд таниулах, сурталчлах, автомашинаа борлуулах энэхүү боломжийг өргөнөөр ашиглахыг бид урьж байна.

Posted date : 2007-07-04

### **ХААН Банк “Авто Экспо 2007” үзэсгэлэнгийн вээр харилцагчдаа баярлууллаа**



Зам Тээвэр Аялал жуулчлалын Яам, Замын Цагдаагийн Газар, Монголын Авто Спорт Аяллын Холбоо, Мишээл ЭКСПО тєв, ХААН Банк хамтран 2007 оны 6 сарын 15-18-ны өдрүүдэд “АУТО ЕХРО 2007” үзэсгэлэн яармагийг хоёр дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.

ХААН Банк зөвхөн энэ өдрүүдэд лизингийн зээлийн хүү, урьдчилгаа төлбөрөө бууруулж харилцагчдадаа бэлэг барихын хажуугаар автомашины лизингийн зээлийн өргөдлийг газар дээр нь хүлээн авч судлан олгосон

байна.

Үзэсгэлэнгийн үеэр ХААН Банкны нэрэмжит 15 азтай зээлдэгч шалгаруулсан бөгөөд азтанууддаа сар бүрийн зээлийн хүүг дахин бууруулах эрх, ХААН Виза Бизнес карт, мөнгөн шагнал, гарын бэлгээр тус тус урамшуулж давхар бэлэг барилаа.



ХААН Банк болон Мишээл Экспо төвөөс машин худалдан борлуулах болон худалдан авах сонирхолтой байгууллага, хүмүүс мөн даатгал, оношлогоо гэх мэт дагалдах үйлчилгээг нэг цэгт төвлөрүүлсэн энэхүү үйл ажиллагаа нь харилцагчдадаа ойртсон, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн үйл ажиллагаа болсон байна.


ХААН Банкны харилцагч О. Чимэд “ Би өнөөдөр ХААН Банкны лизингийн

зээлээр хоёр дахь машинаа худалдан авлаа. Миний хувьд тус банкны зээлийн хөнгөлөлттэй нөхцөлд хамрагдан энэ машинаа худалдан авсандаа баяртай байна. Ялангуяа бүх үйлчилгээг нэг цэгт төвлөрүүлсэн нь бүр ч аятайхан, түргэн шуурхай үйлчилгээ болж чадсан байна” хэмээн сэтгэгдлээ хуваалцлаа.

“Бид үзэсгэлэнгийн үеэр тасралтгүй үйлчлүүлж байгаа харилцагчдаа хараад энэ төрлийн үйл ажиллагааг дахин зохион байгуулах шаардлагатайг мэдэрч ойлголоо. Аль болох ойрын хугацаанд үүнтэй ижил төстэй үйл ажиллагааг зохион байгуулахаар төвлөж байна” гэж ХААН Банкны Бизнес хариуцсан дэд захирал Д. Батсайхан хэллээ.

Posted date : 2007-06-19

**Япон Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл ХААН Банкаар дамжин эзэндээ**



МУ-ын Засгийн газраас хувийн хэвшлийг дэмжих, жижиг дунд вйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор Япон Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх “Жижиг дунд вйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах” хоёр үе шаттай төслийн зээлийг арилжааны 6 банкаар дамжуулан олгохоор шийдвэрлэсний нэг нь ХААН Банк юм. ХААН Банкнаас төслийн нэгжээр дамжуулан Японы Олон улсын хамтын ажиллагааны банкинд хүргүүлсэн эхний 3 төслийн анхных нь батлагдаж, гахайн аж ахуй эрхэлдэг “Зургаан Хошуу” компани энэхүү төслийн анхны зээлдэгчээр шалгарлаа. ХААН Банк энэхүү төслийн зээлийн хөтөлбөрийг эхнээс нь идэвхитэй дэмжиж, идэвхи санаачлагатай ажилласны үр дүнд нийт 80 гаруй төслийн санал хүлээн аваад байгаа бөгөөд харилцагчиддаа хамгийн бага хүү санал болгож байгаа билээ. “Зургаан хошуу” компанийн захирал М. Золзаяа: “Анх 2006 оны 11 сард энэхүү төслийн зээлийн талаар мэдээллийг сонингоос олж уншаад ХААН Банкнд хандсан. ХААН Банкны Инкубатораас зохион байгуулсан төслийн зээлийн сургалтанд хамрагдаж, зөвлөгөө авсаны үндсэн дээр зээлийн судалгаа шинжилгээг эхлэн, төслийн саналаа боловсруулсан юм. Ийнхүү өнөөдөр энэ төслийн зээлийн анхны харилцагч болсондоо баяртай байна. ХААН Банкаар дамжуулан хэрэгжүүлж буй энэ төслийн зээл бизнес эрхлэгчдэд бодитой дэмжлэг болно гэдэгт итгэлтэй байна. Та бүхнийхээ итгэлийг алдахгүй төслөө амжилттай хэрэгжүүлнэ” гэж хэллээ. ХААН Банк 2007 оныг ЖДҮ-ийг дэмжих жил болгон зарласан ба жижиг дунд бизнес эрхлэгчдэд санхүүгийн болон бизнесийн зөвлөгөө өгөх, сургалт явуулах, банкны сүлжээгээрээ дамжуулан бизнесийн түвшнээ олоход нь туслалцаа үзүүлэх зорилготой ХААН Банкны Инкубаторыг байгуулсан билээ. ХААН Банк энэ төвөөр дамжуулан хот хөдөөгийн 1550 гаруй харилцагчдыг хамарсан 40 гаруй удаагийн төслийн зээлийн сургалтыг зохион байгуулж, төсөл бичих, бизнес төлөвлөгөө боловсруулах талаар зөвлөгөө өгсөн нь харилцагчиддаа илүү ойртох, тэдний вйл ажиллагааг бодитойгоор дэмжихийг эрмэлздэгийн нэг илрэл юм.

Posted date : 2007-05-11

**ХААН Банк "Импортын зээл"-ийг танилцуулах бизнес уулзалтыг зохион байгууллаа**  
ХААН Банк 2007 оныг ЖДҮ-ийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан тэдний бизнесийн вйл ажиллагааны онцлогт тохирсон төрөл бүрийн бүтээгдэхүүн, вйлчилгээг санал болгож байгаа билээ. Энэхүү ажлын хүрээнд ХААН Банкны Инкубатораас зээлийн шинэ бүтээгдэхүүн болох “Импортын зээл”-ийг танилцуулах Бизнес уулзалтыг 2007 оны 5 дугаар сарын 9-нд зохион байгууллаа. Монголын зах зээлд импортын худалдааны бизнес давамгайлж байгааг харгалзан бараа, бүтээгдэхүүн импортлон худаалдаалдаг зохих туршлагатай бизнес эрхлэгчдийн санхүүгийн хэрэгцээг хангах, улмаар тэдний бизнесийн вйл ажиллагааг жигд, тогтвортой үргэлжлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор ХААН Банкнаас энэхүү зээлийн шинэ бүтээгдэхүүнийг гаргасан юм. Тус уулзалтад идэвхитэй вйл ажиллагаа явуулдаг тээвэр зуучийн компаниудын, мөн импортлогч компаниудын төлөөлөгчид оролцож санал бодлоо солилцлоо. ХААН Банкны Улаанбаатар хотын зээлийн газрын захирал Я. Түвдэндорж: “Импортын зээл нь импортын худалдаа эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгж байгууллагын импортоор оруулж ирсэн түргэн борлогдох чадвартай бараа, бүтээгдэхүүнд ноогдуулах албан татвар, хураамж, тээврийн хөлсийг төлөх зориулалтаар

олгогдох богино хугацааны зээл бегеед тухайн бараа, бүтээгдэхүүнийг барьцаалан зээл олгох боломжтой юм” хэмээн онцоллоо.

Posted date : 2007-05-09

### **ХААН Банкны нэрэмжит “ШИЛДЭГ БҮТЭЭЛ” шалгаруулах эрдэм шинжилгээний уралдаан амжилттай болж өнгөрлөө**

Хаан Банк уул уурхай, барилга, аялал жуулчлал, боловсрол, эрүүл мэнд, худалдаа үйлчилгээг хөгжүүлэх сэдвүүдээр “ШИЛДЭГ БҮТЭЭЛ” шалгаруулах эрдэм шинжилгээний уралдааныг 2007 оны 3 сарын 1-ний өдрөөс эхлэн 2 үе шаттайгаар амжилттай зохион байгуулж, 5 сарын 1-ний өдөр эцсийн шалгаруулалтыг хийлээ. Тус уралдаан нь улс орны эдийн засаг, бизнес, банк санхүүгийн салбарт судалгаа шинжилгээний ажил хийж буй оюутнууд болон эрдэмтэн судлаачдын эрдмийн үйл хэрэгт дорвитой дэмжлэг үзүүлэх, тэдэнтэй бүтээлчээр хамтран ажиллах зорилготой байсан юм. Энэхүү уралдаанд хот хөдөөгийн оюутнууд идэвхитэй оролцож бүтээлүүдээ ирүүлснээс “Шилдэг бүтээл”-ийн эздээр мэргэжлийн судлаачдаас 3 оролцогч, оюутнуудаас 3 хүн тус бүр шалгарч ХААН Банкны нэрэмжит өргөмжлөл, мөнгөн шагналыг тус тус хүртлээ.

Posted date : 2007-05-01

### **ХААН Банк “Итгэлийн Аян” өдөрлөгийг дэмжив**

ХИС-ийн хэсэг оюутнууд ЗЦГ-тай хамтран 4-р сарын 29-ний өдөр буюу Дэлхийн дулаарлын өдрийг тохиолдуулан “Итгэлийн Аян” өдөрлөгийг зохион байгуулж байна. “Итгэлийн аян”-ны хүрээнд тус сургуулийн оюутан Б. Ууган-Оргилын өвчний талаар олон нийтэд танилцуулж хандив цуглуулах зорилготой юм байна. Б. Ууган-Оргил төрөлхийн нэг өөртэй бөгөөд үндсэн өөр нь архаг дутагдалд орж ажиллагаагүй болон эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байна. Тэрээр ойрын хугацаанд яаралтай хагалгаанд орохгүй бол амь насанд нь аюул учраад байгаа ба өөрсний аппаратын тусламжтай амьдарч байна. Тус аянаар ХИС-ийн 200 оюутнууд ЗЦГ-аас гаргаж өгсөн маршрутын дагуу хотоор дугуй, роликээр аялан явсан юм. ХААН Банк энэхүү сайн санаат оюутнуудыг өөрсний банкны футболк, малгайгаар ижилсүүлж өгсөн юм. Хандивын мөнгө нь ХААН Банкинд Б. Ууган-Оргилын нэр дээр нээгдсэн дансанд цугларч байгаа болно.

Posted date : 2007-04-30

### **Монголын багш, сурагчид АНУ-д аялаад ирлээ**

Нийслэлийн СХД-ийн “Ирээдүй” цогцолбор, Дундговь аймгийн “Эрдмийн ундраа” цогцолбор сургууль тус бүрээс нэг багш, хоёр ахлах ангийн сурагч АНУ-д 10 хоногийн хугацаатай туршлага судлах аялалаар яваад ирлээ. Тэднийг “Америк-Монголын сургуулиудын туншлэл” төслийн хүрээнд аялуулжээ. Аялалын хүрээнд багш, сурагчид жилийн өмнөөс интернэтээр танилцаж, и-мэйлээр харилцаж байсан Денвер хотын “Center for International Studies” (Олон улс судлалын төв) болон Аризона мужын уугуул америкчуудын Greyhills Academy сургуулийн Америк найз нартайгаа нүүр тулан уулзсан юм. Тэд америкчуудад Монголын өс заншил, түүх соёлын талаар танилцуулахын хамт Америкийн хүүхэд багачуудын амьдралтай ойртон танилцаж Колорадо, Аризона мужуудаар аялан Гранд Каньон зэрэг байгалийн үзэсгэлэнтэй газруудыг үзэж сонирхжээ. АНУ-ын талаас төсөлд хамрагдаж буй хоёр сургуулийн төлөөлөгч багш, сурагчид энэ 6-р

сарын эхээр ирж Улаанбаатар хот болон Дундговь аймгаар явж харилцан айлчлахаар бэлтгэлээ хангаж байна. Зориг сан нь Улаанбаатар-Денверийн Ах дvv хотуудын зөвлөл болон АНУ дахь Зориг сантай хамтран хоёр орны ерөнхий боловсролын сургуулиудын хооронд тvншлэл тогтоох төслийг өнгөрсөн хичээлийн жилээс эхлэн хэрэгжvүлж байгаа юм. Төслийн хvрээнд сурагчид, сургуулийн удирдлага, багш нарын хооронд харилцаа тогтоож, тvvx соёлын болоод боловсролын чиглэлээр хамтран ажиллах бөгөөд сургууль тус бүр сурагчдын тусгай клуб байгуулж, хvvxдvүд интернэтээр болон шуудангаар голчлон харьцана. Хоёр орны хvvxэд залуусыг ойртуулан нөхөрлvүлж, харилцан суралцахад нь дэмжлэг vзvүлэх зорилготой энэхvү төслийг Монголын хойч ирээдvй болох хvvxэд залуусын мэдлэг боловсролд бодитой нэмэр хувь оруулагч ХААН Банк Сан болон АНУ дахь Зориг Сан хамтран санхvүжvүлж байгаа бөгөөд Монгол дахь vйл ажиллагааг нь Зориг Сан, АНУ дахь vйл ажиллагааг Улаанбаатар-Денверийн Ах дvv хотуудын зөвлөл удирдан зохицуулж байна.

Posted date : 2007-04-10

### **ХААН Банк барилгын салбарын харилцагчдаа сонслоо**

ХААН Банкны Инкубатороос жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих бас нэгэн арга хэмжээ болох “Сонсоё, Туслая, Дэмжье” нээлттэй хаалганы Төдрvүдийг 100 айл ХААН Банктай хамтран 2007 оны 4 сарын 7, 8-ны Төдрvүдэд амжилттай зохион байгууллаа. ХААН Банкнаас 2007 оныг жижиг дунд бизнесийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан, мТен 4 - 5 сар барилгын материалын худалдаа эрхлэгчид, импортлогчид болон vйлдвэрлэгчдийн хувьд бизнесийн эргэлтийн эхлэлтийн ve байдагтай холбогдуулан зохиогдсон энэхvү нээлттэй хаалганы өдрийн зорилго нь ХААН Банк барилгын салбарын харилцагчдаа сонсох, тэднийг бодитойгоор дэмжихэд оршиж байлаа. Тус Төдрvүдэд 100 айл ХААН Банк болон ХААН Банкны Инкубаторын ажиллагсад харилцагчдаа хvлээн авч, тэдний санал хvсэлт, хэрэгцээ шаардлагыг сонсон бизнесийн зөвлөгөө өгөхийн хажуугаар төрөл бүрийн хөнгөлөлттэй нөхцөл бүхий vйлчилгээнvүдийг санал болгосон нь харилцагчдын эрэлт хэрэгцээнд тохирсон, тэдний зvгээс талархал хvлээсэн vйл ажиллагаа боллоо. Өдөрлөгийн veэр ХААН Банк “Сонсоё” буланг ажиллуулж харилцагчдын саналыг саналын хуудсаар хvлээн авсан ба vйлчлvүлэгчдийн дунд нэрийн хуудасны сугалаа явуулж азтангуудыг банкны нэрийн бэлэг дурсгалын зvйлсээр урамшуулсан зэрэг онцлог vйл явдлаар дvүрэн өнгөрлөө.

Posted date : 2007-04-08

### **ЖДҮ-ийг дэмжих нээлттэй хаалганы өдөр – 2007 оны 4 сарын 7-8-ны өдрvүд**

#### **100 Айл ХААН Банк**

100 айл ХААН Банк салбар нь ХААН Банкны Инкубатортой хамтран 2007 оны 4 сарын 7, 8-ны өдрvүдэд “Сонсоё, туслая, дэмжье” нээлттэй хаалганы өдрийг зохион байгууллаа.

ХААН Банкнаас 2007 оныг жижиг, дунд бизнесийг дэмжих жил болгон зарласан, мөн 4, 5 сар нь барилгын материалын худалдаа эрхлэгчид, импортлогчид болон vйлдвэрлэгчидийн хувьд бизнесийн эргэлтийн эхлэлтийн ve байдагтай холбогдуулан ХААН Банкнаас энэ салбарын харилцагчдынхаа санал хvсэлт, хэрэгцээ шаардлагыг сонсох улмаар тэдний vйл ажиллагааг бодитойгоор дэмжихэд энэхvү vйл ажиллагааны гол зорилго юм.

Тус едерлег нь 100 айл ХААН Банк салбарын байранд зохиогдсон. Энэ едрүүдэд ХААН банкнаас доорхи вйлчилгээг санал болгосон.

- Бизнесийн зевлегес
- Зээлийн хенгелттэй нехцел
  - Импортын зээл
  - Бизнесийн зээл
- Урамшуулалт хадгаламж
- Юаний хенгелттэй шилжүүлэг

Posted date : 2007-04-02

### **ХААН Банк Топ-5 банкны Тэргүүнээр гурван жил дараалан шалгарлаа**



ХААН Банк Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Монгол улсын Засгийн газартай хамтран шалгаруулдаг шилдэг ТОP-5 банкны тэргүүнээр дахин шалгарлаа. ХААН Банк ийнхүү 3 жил дараалан Монгол улсын шилдэг банкуудын хамгийн шилдгээр тодорч байгаа юм. Энэхүү шагнал нь ХААН Банкны хамт олны шургуу хеделмер, Монгол улсын санхүүгийн салбарт оруулж буй хувь нэмэр болон улс орны нийгмийн хөгжилд үзүүлж буй дэмжлэгийг нь өндрөөр үнэлж буйн илэрхийлэл боллоо гэж МVХАVТ-ын Дарга С. Дэмбэрэл тэмдэглэв. “ХААН Банкны харилцагч, хамтран ажилдаг тvншvүд та бvхний бидэнд үзүүлсэн дэмжлэгт чин сэтгэлээсээ талархаж цаашид ч бид Монгол орон даяарх харилцагчдынхаа хэрэгцээ, шаардлагыг хангахын зэрэгцээ нийгмийн сайн сайханд бодитой хувь нэмэр оруулахын тулд бvх хvчин чармайлтаа дайчлахаа илэрхийлж байна” гэж ХААН Банкны орлогч

захирал С. Сүхболд өргөмжлөл гардуулах ёслолын үеэр хэллээ. Оны шилдэг аж ахуйн нэгж, банкуудад өргөмжлөл гардуулах ёслолын ажиллагаа 2007 оны 3 дугаар сарын 22-ны өдөр Баянгол зочид буудалд болсон бөгөөд Төр, засгийн удирдлагууд өргөмжлөл гардууллаа.

Posted date : 2007-03-26

### **ХААН Банк, КЕВанк хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурлаа**



Монгол Улсын шилдэг банк болох ХААН Банкны урилгаар Солонгосын Korea Exchange Bank (КЕВ)-ны Иргэдийн банкны Захирал Ким Гви Хьүн тэргүүтэй төлөөлөгчид энэ оны 3 сарын 19-22-ны хооронд Улаанбаатарт айлчиллаа. Айлчлалын үеэр ХААН банкны вйл ажиллагаатай танилцаж, хамтын ажиллагааны хэлбэр, түүнчлэн БНСУ-д гэрээгээр ажиллаж буй монгол иргэдийн мөнгөн шилжүүлэг, гуйвуулгыг ХААН Банк, КЕВ-аар дамжуулан

гүйцэтгэх ажлын хэрэгжилт явцыг хэлэлцэж, иргэдэд үзүүлэх банкны вйлчилгээг хөнгөн

шуурхай, зардал багатай, харилцагчдад ашигтай хэлбэрээр гүйцэтгэх талаар санал солилцов. ХААН Банк, КЕВ нь хоёр банкны хооронд хэрэгжүүлж буй хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилгоор Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурлаа. Энэхүү Харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу талууд хамтын ажиллагааны шинэ хэлбэрүүдийг хэрэгжүүлж, мөн түүнчлэн маркетингийн төлөвлөгөөгөө хамтран гүйцэтгэж, ажилтан харилцан солилцож, Солонгост гэрээгээр ажиллаж, оршин сууж буй монгол иргэдэд үзүүлэх үйлчилгээгээ цогц, илүү боловсронгуй болгох аж. Харилцан ойлголцлын санамж бичигт ХААН Банкны Гүйцэтгэх захирал Ж.Питер Морроу, Korea Exchange Bank (КЕВ)-ны Иргэдийн банкны Захирал Ким Гви Хьун нар гарын үсэг зурав. Айлчлалын үеэр КЕВ-ын төлөөлөгчид Монгол Улсын Сангийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Нийгмийн даатгалын газар зэрэг төрийн яам, газрууд дээр уулзалт хийж, Солонгос улсад ажиллаж буй Монгол иргэдэд үзүүлж буй банкны үйлчилгээний ач холбогдлыг хэлэлцэн Монгол Улс, Солонгосын тэргүүний хоёр банкаар дамжуулан хэрэгжүүлж буй энэхүү ажиллагаа нь монгол иргэдийн нийгэм, эдийн засгийн эрх ашгийг хамгаалан дэмжихэд чиглэгдэнэ гэдгийг уулзалтуудын үеэр онцгойлон тэмдэглэв.

Posted date : 2007-03-25

### **Глобал Файнанс сэтгүүл ХААН Банкыг Монголын Шилдэг банкаар дахин**

#### **тодрууллаа**



Нью-Йорк дахь Глобал Файнанс сэтгүүл Монгол Улсын ХААН Банкыг

“2007 оны Монголын шилдэг банк”-аар тодрууллаа. Ийнхүү тус сэтгүүл дөрөв дэх удаагаа дараалан ХААН Банкыг Монголын том байгуулагуудад үйлчилдэг шилдэг банк хэмээн нэрлэлээ. Энэхүү шалгаруулалтыг тус сэтгүүлийн эрхлэгчид уг салбарын шинжээчид, том компаниудын гүйцэтгэх захирлууд болон банкны зөвлөхүүдийн оролцоотойгоор явуулсан байна. Уг сонголтын гол шалгуур үзүүлэлтүүд нь активын өсөлт,

ашиг, стратегийн харилцаа холбоо, харилцагчийн үйлчилгээ, үнийн өрсөлдөх чадвар болон шинэ бүтээгдэхүүн юм. ХААН Банкны Гүйцэтгэх захирал Ж. Питер Морроу “Энэхүү шагнал нь ХААН Банк монголчууд болон гадны хөрөнгө оруулалттай компаниудад чанартай үйлчилгээ үзүүлдэг болохыг хүлээн зөвшөөрч онцлон тэмдэглэсэн гэдгийг харуулж байна. Ийм амжилтад хувь нэмрээ оруулсан ажилтнуудаараа бахархахын зэрэгцээ өөрсдийнхөө банкны хэрэгцээг биднээр үйлчлүүлдэг үнэнч харилцагчиддаа цаг ямагт талархаж явдгаа илэрхийлье” гэж хэллээ.

Posted date : 2007-03-25

### **“Барилгын санхүүжилт – 100 Зээлийн эдийн засагч” Үзэсгэлэн яармаг**

Тус үзэсгэлэн яармагийг ХААН банк, Орон Сууцны Санхүүжилтийн Корпораци болон Барилгын Бирж хамтран зохион байгуулах юм.

ОССК нь Улаанбаатар хотод шинээр баригдаж байгаа болон цаашид баригдах орон сууцны хороолол, Ипотекийн зах зээл Монголд хэрхэн хөгжиж байгаа талаар хамгийн шинэ, үнэн зөв мэдээллийг хүргэх, Барилгын бирж нь үзэсгэлэн яармагт оролцох компаниудыг зохион байгуулах, ХААН Банк нь хоёр өдрийн турш 100 зээлийн эдийн засагчаараа дамжуулан барилгын салбарын бизнес эрхлэгчдэд тохиромжтой зээлийн

бүтээгдэхүүнийг санал болгож зээлийн хүсэлтийг газар дээр нь хүлээн авч судлах болно.

Энэхүү үзэсгэлэн яармаг нь барилгын зах зээл дэх үйлдвэрлэл эрхлэгчид, үйлчилгээ үзүүлэгчид болон худалдан авагчид цуглан барилгын салбарын болон банкны санхүүжилтийн цогц мэдээллийг нэг дороос авах боломж бүрдүүлж байгаагаараа ач холбогдолтой юм.

Мөн үзэсгэлэнгийн үеэр ХААН Банк танд зориулан орон сууц, хашаа байшин худалдан авах зээлийн хүүгээ 1.5% хвртэл бууруулж байгааг мэдэгдэхэд таатай байна.

Таныг “БАРИЛГЫН САНХҮҮЖИЛТ - 100 ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГЧ” үзэсгэлэн яармагт хврэлцэн ирэхийг урьж байна.

Posted date : 2007-02-27



### **ХААН Банк Сан байгуулагдан 100 сая төгрөгийн хандив өргөлөө**

Өнөөдөр ХААН Банк нийгэм, олон нийтэд бодитой дэмжлэг үзүүлэх замаар хүмүүсийн амьдралд нааштай өөрчлөлт хийх зорилго бүхий ХААН Банк Сан-г байгуулсанаа олон нийтэд зарлалаа. Энэ үеэрээ мөн шинээр байгуулагдсан ХААН Банк Сан анхны ивээн тэтгэлэг, хамтран ажиллах түнш байгууллагуудаа мөн зарласан байна. ХААН Банкны хувьд боловсрол, соёр урлаг, нийгмийн чиглэлийн аливаа үйл ажиллагааг байнга тогтвортой дэмждэгээрээ олон нийтэд ихээхэн нэр хүндтэй билээ. Энэ тухайгаа тус банкны гүйцэтгэх захирал П. Морроу “Бид ХААН Банкны салбар нэгж бүр үйл ажиллагаа явуулдаг Монгол орны өнцөг булан бүрт ажиллаж амьдарч буй хүмүүс, олон нийтийн өмнө хүлээсэн нийгмийн хариуцлагаа хэрхэн ухамсарлан биелүүлэхээс манай санхүүгийн амжилт шалтгаалдаг гэдгийг ойлгодог юм. Шинээр байгуулагдаж буй ХААН Банк Сан нь боловсрол, соёр урлаг, нийгмийн хөгжилд хүчтэй, бодитой хувь нэмэр, дэмжлэг үзүүлэх олон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд илүү анхаарч үйл ажиллагаагаа чиглүүлэх болно” гэв. ХААН Банк Сан албан ёсны нээлтийн ажилагааныхаа үеэр хот хөдөөгийн орлого багатай ерхийн 100 оюутан сурагчдад “Сургалтын тэтгэлэг” олгох хөтөлбөрөө зарласан юм. Түүнээс гадна олон нийт, нийгмийн чиглэлээр хамтран ажиллах дараах төсөл, хөтөлбөрүүдэд дэмжлэг үзүүлэхээ мөн мэдэгдсэн болно. Үүнд: • Азийн Сангийн “Явуулын номын сан” хөтөлбөр • Английн Хүүхдийг Ивээх Сангийн “Олон нийтэд түшиглэсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхөн сэргээх төв” төсөл • АНУ-ын Энх тайваны корпусын “Хөдөө орон нутгийн олон нийтийг хөгжүүлэх хөтөлбөр” • Азийн Нүүдэлчдийн Өв Сангийн “Нүүдлийн соёл иргэншил дэх эртний эдлэлийн судалгаа, хэвлэн нийтлэл” хөтөлбөр • Зориг Сантай хамтарсан Америк- Монголын сургуулиудын түншлэл төсөл • Монголын Урлагийн Зөвлөл зориулсан МУЗ-ийг дэмжих тэтгэлэг • Кембриджийн Их Сургууль, МУИС-ийн хамтрал 20 р зууны Монголын аман түүх төсөл • ИЭСПИ Сантай хамтран “Войс бокс” Хүүхэд залуучуудад зориулсан теле нэвтрүүлэг зэрэг төслүүдэд нийт 100 гаруй сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах болно. ХААН Банк Сан нь ХААН Банкны нэг хэлтэс болж ажиллаж бөгөөд тус банкны Хүний нөөцийн асуудал эрхэлсэн дэд захирал Э. Оюунбилэгээр ахлуулсан Төлөөлөн удирдах Зөвлөлд үйл ажиллагаагаа тайлагнах юм.

Харин тус Сангийн Гүйцэтгэх захирлаар ХААН Банкны Маркетингийн газрын захирал А. Ганчимэг ажиллах болно.

Posted date : 2007-02-26

### **MVХАVТ-аас ХААН Банкыг 2006 оны шилдэг аж ахуйн нэгжээр тодруулав**

MVХАVТ нь бизнес эрхлэгчдийнхээ тухайн ондоо олсон ололт амжилтыг тодруулан олон нийтийн хүртээл болгох зорилгоор зохион байгуулдаг ENTREPRENEUR - 2006 үндэсний хэмжээний арга хэмжээ 12-р сарын 28-нд болж өнгөрлөө. 2006 оны шилдэг аж ахуйн нэгж шалгаруулах арга хэмжээний онцлог нь аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагаа явуулж буй салбар, нийгэм эдийн засгийн хөгжилд оруулсан хувь нэмрээр нь үнэлж үндэсний хэмжээний ТОП-10 байгууллагыг шалгаруулсан. 2006 онд банк санхүүгийн оновчтой маркетинг, менежмент хэрэглэж шинэлэг үйлчилгээ нэвтрүүлэн, амжилттай ажиллахын зэрэгцээ, нийгмийн салбарт оруулсан хувь нэмэр зэрэг үзүүлэлтээр ХААН Банк 2006 оны Шилдэг аж ахуйн нэгжээр шалгарлаа, ХААН Банк нь 2002 оноос хойш MVХАVТ-аас шалгаруулдаг ТОП-10 аж ахуйн нэгжид шалгарч ирсэн ба 2004, 2005 онуудад ТОП-5 банкны 1-ээр шалгарч үйл ажиллагаагаа үнэлүүлсэн юм. ХААН Банкны орлогч захирал С. Сүхболд шилдэг аж ахуйн нэгжийн шагнал гардаж авах үедээ “2006 онд Монгол улсын эдийн засаг сайжирч, ажлын байр нэмэгдэж ардчиллын үр шимийг амссан амжилт бүтээлээр дүүрэн он байлаа. 2006 он нь ХААН банкны хувьд ч таатай жил болж ТенгТерлТеҮе. 9-р сард бид Монгол улсын хэмжээнд тэргүүлэх зээлдүүлэгч, тэргүүний татвар ТелТөгч байгууллагагаар шалгарсан ТөгТөгд эдгээр амжилтыг гаргахад бидэнд тус болсон харилцагчиддаа талархал илэрхийлье. ХААН банк бусад арилжааны банкуудаас илүү олон зээлийг олгодог ба үүнийгээ 2007 онд ч үргэлжлүүлэх зорилготой байна. Үүнээс гадна нэн тэргүүнд бид ТеҮерийн үйл ажиллагаа явуулж буй нутгийн нийгмийн асуудалд анхаарна гэдгээ хэлмээр байна. Учир нь ард түмний ахуй орчин сайжирч амьдрал дээшлэхийн хирээр манай банкны үйл ажиллагаа улам ТөгТөгжих нь дамжиггүй” гэж хэллээ.

Posted date : 2007-01-16

### **ХААН Банк Нийгмийн Чиглэлийн Шилдэг Маркетер - шагналыг хүртлээ**

Маркетингийн шилдэг ололт амжилтуудыг тодруулж, олон нийтэд сурталчилах зорилгоор Монголын Маркетингийн Холбооноос анх удаа зохион байгуулагдаж буй “Best Marketing – 2006” шалгаруулалтын үйл ажиллагааны шагнал гардуулах арга хэмжээ 2006 оны 12 сарын 31-нд болж өнгөрлөө. 2006 онд нийгмийн чиглэлийн идэвхитэй үйл ажиллагаагаараа Монголын урлаг, соёл, боловсролын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсан ХААН Банк “Best Social Marketing-2006” шагнал хүртсэн. ХААН Банкныг 2006 оны туршид нийгмийн янз бүрийн салбарт ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийж, олон нийтэд тустай өргөн цар хүрээтэй төсөл санаачилгууд тухайлбал, Хөдөө орон нутгийн хүүхдүүдийг Англи хэлний сургалтын нэмэлт материалаар хангах, хөдөөгийн алслагдмал сумдад Интернет кафе нээн ажиллуулж эхэлсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд туслах хандивын аяныг салбар нэгжүүдээрээ дамжуулахн зохион байгуулсан гэх мэт олон тооны төслүүдийг амжилттай хэрэгжүүлсэнийг нь үнэлэн ийнхүү өргөмжилсөн байна. Энэ тухай ХААН Банкны Маркетингийн газрын захирал А. Ганчимэг хэлэхдээ, “Монгол орны өнцөг булан бүрт ажиллаж амьдарч буй айл өрх, хүн амын ахуй амьдралыг эерэгээр өөрчлөн сайжруулахад дэмжлэг үзүүлнэ гэдэг бол манай банкны чин эрмэлзэл, зорилго юм.

Єнгєрсєн жил бидний хэрэгжүүлсэн нийгмийн янз бүрийн давхаргын, янз бүрийн насны хvмvвєт зориулсан вйл ажиллагааг vнэлж шагнасан явдалд баяртай байна. ХААН Банк 2007 онд нийгмийн сайн сайхны тусын тулд хийх хєрєнгє оруулалт, санал санаачилгаа улам ергєжvүлж, улам олон хvн, олон нийтийн бvлгvүдэд хvрч ажиллах болно” гэв.  
Posted date : 2007-01-09

**ХААН Банк олон хvүхдvүдийн баяр дээр баяр нэмэв**

Хуучин оноо vдэж, шинэ оноо угтах зааг дээр Монголын ирээдvй болсон хvүхэд багачуудыг дэмжин ажилладаг ХААН Банкны ах эгч нар нь хєгжлийн бэрхшээлтэй хvүхдvүдийн эцэг эхийн холбооноос зохион байгуулсан сvлд модны наадамд оролцсон хєгжлийн бэрхшээлтэй 400 хvүхдэд шинэ жилийн бэлэг егч баярлуулав. Тvүнчлэн тус банкныхан Хан-Уул дvүргийн 63-р сургуулийн сурагчид болон 29-р тусгай дунд сургуулийн сурагчдад шинэ жилийн бэлэг мєн бичгийн хэрэгсэл бэлэглэсэн юм байна. Дашрамд хэлэхэд ХААН Банк нь 29-р сургуулийн хvүхдvүдэд жил бvр уламжлал болгон бэлэг егдєг юм байна.  
Posted date : 2007-01-09